

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 2025 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан гүйцэтгэсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/005/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:
www.audit.mn
Орхон аймаг
2026 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buynundrakhb@audit.gov.mn
Аудитор: Г.Даваасүрэн
Утас: 70359826 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. ТҮҮВЭРТ ХАМРУУЛАН АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭИ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	422,058,313.03	408,566,854.21
1.1	Кассад байгаа бэлэн мөнгө	-	-
1.2	Жижиг мөнгөн сан	-	-
1.3	Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	422,058,313.03	408,566,854.21
2	АВЛАГА	808,063,622.00	863,793,465.24
2.1	Байгууллагаас авах авлага	473,631,154.00	628,444,287.29
2.2	Хувь хүмүүсээс авах авлага	334,432,468.00	235,349,177.95
3	БАРАА МАТЕРИАЛ	-	-
3.1	Бичиг хэргийн материал	-	-
3.2	Аж ахуйн материал	-	-
6	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,230,121,935.03	1,272,360,319.45
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	-
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
8.1	Биет бус хөрөнгө	-	-
8.1.1	Программ хангамж	1,950,000.00	1,950,000.00
8.1.2	Хуримтлагдсан элэгдэл	(1,950,000.00)	(1,950,000.00)
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
10	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,230,121,935.03	1,272,360,319.45
11	Богино хугацаат өр төлбөр	-	-
12	Өглөг	-	-
13.1	Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	-
13.2	Бусад өглөг	901,000,000.00	901,000,000.00
13.3	Урьдчилж орсон орлого	-	-
13.4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	901,000,000.00	901,000,000.00
14	Урт хугацаат зээл	-	-
14.1	УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
15	НИИТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	901,000,000.00	901,000,000.00
16	Засгийн газрын сан	-	-
17	Орон нутгийн сан	-	-
18	Хуримтлагдсан үр дүн	329,121,935.03	371,360,319.45
18.1	Өмнөх үеийн үр дүн	291,317,541.48	329,121,935.03
18.2	Тайлант үеийн үр дүн	37,804,393.55	42,238,384.42
19	Бүртгэлийн өөчлөлт	-	-
20	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	329,121,935.03	371,360,319.45
21	ӨР ТӨЛБӨР. ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,230,121,935.03	1,272,360,319.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	43,527,168.55	46,627,384.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	43,527,168.55	46,627,384.42
120	Нийтлэг татварын бус орлого	43,527,168.55	46,627,384.42
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,527,168.55	46,627,384.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,179,896.48	22,732,161.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,347,272.07	23,895,223.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	5,722,775.00	4,389,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,722,775.00	4,389,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,722,775.00	4,389,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,100,000.00	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210402	Тээвэр шатахуун	700,000.00	600,000.00
210403	Шуудан холбоо	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,622,775.00	3,389,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,123,775.00	3,389,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	-
	Бусад зардал	499,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (1П)=(1)-(П)	37,804,393.55	42,238,384.42
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
4.1	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз(бодит)	-	-
4.2	Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
5.1	Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	-	-
5.2	Барилга байгууламжийн зардал	-	-
5.3	Тоног төхөөрөмжийн зардал	-	-
5.4	ЗГ-ын дотоод шилжүүлэг	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН	37,804,393.55	42,238,384.42

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	43,527,168.55	46,627,384.42
12	Татварын бус орлого	43,527,168.55	46,627,384.42
120	Нийтлэг татварын бус орлого	43,527,168.55	46,627,384.42
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	43,527,168.55	46,627,384.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,179,896.48	22,732,161.02

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,347,272.07	23,895,223.40
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,223,775.00	4,389,000.00
21	Урсгал зардал	5,223,775.00	4,389,000.00
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	5,223,775.00	4,389,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,100,000.00	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	400,000.00
210402	Тээвэр, шатахуун	700,000.00	600,000.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,123,775.00	3,389,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,123,775.00	3,389,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	38,303,393.55	42,238,384.42
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	136,538,349.12	(55,729,843.24)
14	Бусад эх үүсвэр	286,538,349.12	266,970,156.76
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	286,538,349.12	266,970,156.76
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	150,000,000.00	322,700,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000,000.00	322,700,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	174,841,742.67	(13,491,458.82)
30	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн С1	247,216,570.36	422,058,313.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн С2	422,058,313.03	408,566,854.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	/төгрөгөөр/
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	292,318,048.69	292,318,048.69
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,000,507.21)	(1,000,507.21)
Тайлант үеийн үр дүн	37,804,393.55	37,804,393.55
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	329,121,935.03	329,121,935.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
Тайлант үеийн үр дүн	42,238,384.42	42,238,384.42
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	371,360,319.45	371,360,319.45

3. Аудитын илрүүлэлт:

Аудитаар илэрсэн 3 зөрчилд зөрчлийн асуудлын бүртгэл хөтлөн баталгаажуулж, 3 зөвлөмж хүргүүлж байна. Үүнд:

Зөвлөмж:

Илрүүлэлт 1: Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох сумын Засаг даргын захирамжийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:", 3.1.4-д "улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага;", 3.2-д "Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна:", 3.2.6-д "Засгийн газар, орон нутгийн гадаад болон дотоод зээл, буцалтгүй тусламж;", Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 8.3-д "Зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ." гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээллэж хэвших

Илрүүлэлт 2: Хоршоог хөгжүүлэх сан нь сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилготой боловч Булган аймаг болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 4 хоршоонд 322,700.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Энэ нь "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.3-д "Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх хоршоо нь дараах шаардлагыг хангасан байна", 6.3.1-д "тухайн суманд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг байх", 6.4-д "Энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан хоршооны боловсруулсан төсөл дараах нийтлэг шалгуурыг хангасан байна:", 6.4.1-д "тухайн суманд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн нөөцөд түшиглэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх;" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн зээлийн шалгаруулалтыг сонгохдоо орон нутагт тогтвортой ажлын байрыг бий болгох, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэх.

Илрүүлэлт 3: Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, төсөл сонгон шалгаруулах тухай мэдээллийг олон нийтийг мэдээллээр хангах үйл ажиллагаа хангалтгүй байна.

Энэ нь Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.1.5-д "хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг бэхжүүлэх, сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, энэ журмын 2.7-д заасан санхүүжилтээр сургалт зохион байгуулах сургалт зохион байгуулах;", 8.3-д "Зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хягаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1		1					
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1		1					